



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 434.

Улаанбаатар хот

Хувьчлалын тайлан батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4, 65 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр баг, 2 дугаар хорооллын нутаг дэвсгэрт байрлалтай “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй компанийн эзэмшлийн 500 м2 газар бүхий амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын хувьчлалын тайланг баталсугай.

2. Батлагдсан тайланг холбогдох баримт бичиг, материалын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын архивд хүлээлгэн өгөхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу хийж, бүртгэлээс хасахыг “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Т.Жаргалсайханд үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ